



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 800

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан, нийт 38,450,000.00 (гучин найман сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч хошууч Ч.Цэгмэд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай::

2.1.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007428

37-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26 өдрийн
800 дугаар тогтоолын хавсралт



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР (ШАЛГАН
НЭВТРҮҮЛЭХ БАЙР)-ЫГ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн байршил нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, /бүртгэх үнэ/ (төгрөг)
1	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13 дугаар баг, Шалган нэвтрүүлэх байр	2022	м.кв	48	38,450,000.00
Нийт дүн					38,450,000.00
					(гучин найман сая дөрвөн зуун тавин мянга)